




ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2016-2017 оны үйл
ажиллагааны үр дүн



Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд
төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг
тооцож ажиллах шаардлагатай байна

2018 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Бүлэг 1: Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа	1.1. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.
Аудитын менежер Г.Наранбаяр	1.2 Салбарын бодлого, чиглэлийг баримтлан орон тооны дээд хязгаарт нийцүүлэн бүтэц, орон тоог баталсан байна.
Ахлах аудитор Ц.Батсайхан	1.3 Ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй ажилтныг авч ажиллуулсан, ажлын байрны сул орон тоо нөхөгдөөгүй байна.
Аудитор Б.Дарханбат	1.4 Үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.
Аудитор М.Ундармаа	Бүлэг 2: Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчсөн байна.
2018 оны 06 дугаар сар	2.1. Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, тооцоолол хангалтгүй байна.
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.	2.2. Орлогыг нэр төрлөөр нь төлөвлөөгүй, орлогыг төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна.
ХАЯГ:	2.3. Төсвийн зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчиж, цалингийн зардлаас тэтгэмж олгосон байна.
Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 209 тоот	2.4. Үйлчилгээний болон тарилгын хөлсний үнэ тарифыг эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрээр батлуулж, баримталж ажилласан байна.
	2.5. Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан байна.
	Бүлэг 3: Хөрөнгийн эмх цэгц сайн боловч хөрөнгийг дансны ангиллын дагуу бүртгээгүй, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.
	3.1. 2016-2017 онд хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүй байна.
	3.2. Үндсэн хөрөнгө, тусгай зориулалтын материалыг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгээгүй байна.

3.3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Бүлэг 4: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

4.1. Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

4.2. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

4.3. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайн байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Хавсралтууд.....

Товчилсон үгийн тайлбар

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
УИХ	Улсын их хурал
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
НД	Нийгмийн даатгал
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг ариун цэвэрийн төв лаборатори
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
ХШУДА	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит
МААХ	Мал аж ахуйн хэлтэс
ХГТХ	Хүнс, газар тариалангийн хэлтэс
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын захиалгын дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт:

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Хүнс, аж ахуйн газрын 2016-2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон санхүүгийн тайлан, хүний нөөцийн судалгаа, бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримтууд, холбогдох бусад, мэдээ, судалгааг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ АДБОУС 3000-3100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох ажилтнуудаас шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, санал асуулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

3. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны хяналтыг хийж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор М.Ундармаа, Б.Дарханбат нар гүйцэтгэв.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7.Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад мэдээ, судалгааг үнэн зөв гаргаж ирүүлээгүй, Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга, жижиг дунд үйлдвэр хоршоо бирж, ахуйн үйлчилгээ, экстейншны асуудал хариуцсан мэргэжилтэн, мал эмнэлгийн албаны дарга

нараас шаардлагатай мэдээ, судалгааг, баримт материалыг цаг хугацаанд нь шуурхай ирүүлээгүй зэргээс аудитын хугацаа сунгагдсан болно.

8. Үндсэн мэдээлэл

1931 онд Оцол сансар уулын хажуу, одоогийн Төв аймгийн Сүмбэр суманд сумдын мал эмнэлгийн алба, 1948 онд Дорноговь аймгийн Сүмбэр сумын мал эмнэлгийн тасаг, 2016 онд Засгийн газрын 81 дүгээр тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэй болж, Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний, Мал эмнэлгийн, Мал аж ахуйн гэсэн 3 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

ХХААГ нь 2016 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 163,063.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,500.0 мянга, 2017 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 163,555.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,500.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө тус тус батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2016 онд санхүүжилт 163,063.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 2,375.8 мянга, 2017 онд санхүүжилт 163,555.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,566.7 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2016 онд 164,563.4 мянга, 2017 онд 165,055.8 мянган төгрөгийг тус тус үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц сан, Мал эмнэлэг үржлийн газар, НҮБ-ийн ХХААГ, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори зэрэг газруудаас Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 2016 онд 145,554.8 мянга, 2017 онд 175,121.8 мянга, нийт 320,676.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулж аймгийн ОНХС-гийн санхүүжилтээр 2016 онд 19,765.3 мянга, 2017 онд 16,826.5 мянган төгрөгийг тус тус авч, зарцуулсан байна.

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 2017 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Тус газар нь 2016 онд 607,272.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 194,169.3 мянган төгрөгийн бараа материал, 2017 онд 644,582.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 118,255.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

2016 онд үндсэн хөрөнгө нийт 1,550.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс 1,550.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг УМЭАЦТЛ-оос үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

2017 онд 2012 оны Монгол улсын засгийн газрын 224 дүгээр тогтоол, Говьсүмбэр аймгийн Орон сууц хувьчлах хорооны 01 тоот тогтоолыг үндэслэн Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 332 дугаартай албан бичгээр 4 ерөө орон сууц 7,091.0 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 346 тоот тогтоолоор 5 төрлийн тоног төхөөрөмж 3,838.2 мянга, нийт 10,929.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Бүлэг 1

Салбарын бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байна.

1.1. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ХХААГ нь салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг харъяалах нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаар хангах, сургалт сурталчилгаа хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нь ХХААХҮ-ийн Сайд болон аймгийн Засаг даргатай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулж, дүгнүүлэн ажилласан байна.

2016 оны үр дүнгийн гэрээнд гурван бүлэг 55 арга хэмжээг, 2017 оны үр дүнгийн гэрээнд гурван бүлэг 53 арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ХХААХҮ-ийн Сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг 2016 онд 81%, 2017 онд 83%, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг 2016 онд 80.5%, 2017 онд 88%-тай тус тус дүгнүүлсэн байна.

2016 онд төлөвлөсөн ажлаас 32 ажил бүрэн хэрэгжээгүйгээс 27 ажил нь 50.0-90.0%, 5 ажил нь 50.0%-иас доош гүйцэтгэлтэй бөгөөд үүнээс 2 ажил нь огт хэрэгжээгүй, 1 ажил нь 30.0%, 2 ажил нь 10.0%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

1. Сүүний чиглэлийн үхрийн ферм бий болгох ажлын хүрээнд Сүмбэр сумын СХС-гаас 1 иргэнд сүүний үнээний ферм бий болгохыг дэмжиж 10 сая төгрөгийг зээл олгосон - хэрэгжилт 30%
2. УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны төлөвлөгөөг аймгийн түвшинд боловсруулж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд төлөвлөгөөг эхний байдлаар боловсруулсан боловч улсын хэмжээнд ХХАА-н талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг батлахтай холбогдуулан хүлээгдсэнээс шалтгаалж хүчин төгөлдөр болоогүй хэрэгжилт 10%
3. УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд-Улсын хэмжээнд ХХАА-н талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг батлахтай холбогдуулан хүлээгдсэнээс хэрэгжилт 10%
4. Бод, бог малын ангилагч-шинжээч бэлтгэх сургалтад мэргэжилтнүүдийг хамруулах гэсэн ажлын хүрээнд сум бүрээс 1-ээс доошгүй мэргэжилтнийг хамруулахаар төлөвлөсөн боловч сумдад байгаа мэргэжилтэнгүүд шаардлага хангаагүйгээс хэрэгжээгүй.

- Биржийн арилжаанд орон нутгаас оролцох боломжийг хангах, 1-ээс доошгүй малчдын хоршоонд сум хөгжүүлэх сангаас дэмжлэг үзүүлэх ажил нь сум хөгжүүлэх сангаас зээл олгогдоогүйгээс тус тус хэрэгжээгүй байна.

Харин 2017 онд төлөвлөсөн ажлаас 24 ажил бүрэн хэрэгжээгүйгээс 19 ажил 70%, 5 ажил 50.0%-иас доош гүйцэтгэлтэй байгаа бөгөөд үүнээс 2 ажил нь огт хэрэгжээгүй, 3 ажил нь 30.0%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Бог, бод малын ангилагч-шинжээч бэлтгэх ажлын хүрээнд ХХААХҮЯ, ХААИС-иас Бод, бог малын ангилагч-шинжээч бэлтгэх сургалтыг зохион байгуулсан боловч тухайн үед сумдын мал эмнэлгийн үржлийн тасгууд орон тоо дутуу ажилласнаас мэргэжилтнүүд хамрагдаагүйгээс хэрэгжилт 30%-тай
- “Инвест ко-оп монгол” төсөлтэй хамтарч БНХАУ-ын ӨМӨЗО-оос Үзэмчин үүлдрийн үржлийн хээлтүүлэгч авч малын чанар сайжруулах арга хэмжээ авах ажлыг төлөвлөсөн боловч тус төслийн төлөвлөгөөнд тухайн ажил нь батлагдаагүйгээс хэрэгжилт 30%-тай
- Хоршоодын үйл ажиллагааг дэмжих Хөдөө аж ахуйн брокерийн сургалтанд хамруулж ажиллах ажлын хүрээнд хоршоологчдын холбооноос зохион байгуулж буй брокерийн эрх авах сургалтын талаарх мэдээллийг хөдөө аж ахуйн чиглэлийн 9 хоршоонд хүргэсэн боловч сургалтанд хамрагдсан хоршоо байхгүй тул хэрэгжилт 30%-тай
- Сум бүрт түүхий эдийн анхан шатны тордолтын цех, агуулахад орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэх, сургалт арга зүй, удирдлагаар хангах хамтран ажиллах ажлын хүрээнд түүхий эдийн анхан шатны тордолтын цех, агуулах байгуулах чиглэлээр санаачлага гаргасан иргэн, аж ахуй нэгж байхгүй, МХС, ЖДСХДС-аас төсөл хөтөлбөр хэрэгжээгүйгээс уг ажил хэрэгжээгүй байна.
- Худалдааны тухай хууль, Дэмпингийн тухай хуулийн төсөл боловсруулан батлуулж хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлын хүрээнд тус хуулиуд нь батлагдаагүйгээс хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, уг ажил хэрэгжээгүй байна.

Аймгийн Засаг даргатай жил бүр байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үндсэн чиг үүргээс гадна Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт салбарын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээнүүд тусгагдсан байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний 2016-2017 оны хэрэгжилтийг дараах хүснэгтээр харуулбал:

Д/д	Чиглэл	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хувь
			Төлөвлөсөн	Хэрэгжсэн	
1	Худалдаа үйлчилгээ	Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	1	1	100
2	Хүнсний үйлдвэрлэл	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах	4	2	50
3	Мал аж ахуйн	Бэлчээр бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлэх	4	4	100
4	Мал аж ахуйн	Эрчимжсэн аж ахуйг дэмжих, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	2	1	50

5	Мал эмнэлэг	Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх	4	3	75
5	Газар тариалан	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	4	3	75
6	Хөнгөн үйлдвэрлэл	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	3	1	33
7	Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр	Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	3	1	33
Нийт дүн			25	16	

Хүснэгтээс харахад: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаар тусгагдсан арга хэмжээний биелэлт 64%-тай хэрэгжиж байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагаа нь сумдын МЭҮТ-ийн үйл ажиллагаатай нягт уялдаатай бөгөөд сумдаас ирүүлсэн мэдээ, тайланд үндэслэн салбарын бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Аудитын явцад сумдын МЭҮТ-аас 2016-2017 оны үйл ажиллагааны тайлан мэдээг ирүүлэх талаар албан тоот хүргүүлсэн боловч тайланг ирүүлээгүй, зөвхөн вакцинжуулалтын тарилгын ажлын хөлс олгосон анхан шатны баримт материалыг ирүүлсэн байна. Иймд сумдын хэмжээнд ХАА-ын салбарын бодлого, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь салбарын бодлого, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 3 албатай үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний алба:

Тус алба нь Хүнс, газар тариалан, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, хоршоо, бирж, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг мэргэжил, арга зүйгээр болон зөвлөх үйлчилгээгээр хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд 2016 онд 22, 2017 онд 17 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2016 оны ажлын гүйцэтгэл 85.5%, 2017 оны ажлын гүйцэтгэл 66.4%-тай байна.

Тус албаны үйл ажиллагаа үндсэн чиг үүргийн дагуу ерөнхийлсөн байдлаар 3 салбарт хуваагдаж байна. Үүнд:

- Хүнсний салбарын чиглэлээр орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэмжих, мах, сүү, өндөгний хэрэгцээний тодорхой хувийг дотоодоосоо хангадаг болох, “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна

Аймгийн хэмжээнд 2016-2017 оны хүн амын хүнсний гол 5 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тооцоолол хийж дотооддоо хангах зорилт тавин ажилласан ажилласан байна.

2016-2017 онд аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангасан байдлыг өмнөх онтой харьцуулж бүтээгдэхүүний нэр, төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

Д/д	Бүтээг-дэхүүний нэр	Хэмжих нэгж	2017 он			2016 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аймгийн нийт хэрэгцээний хангалт /хувиар/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аймгийн нийт хэрэгцээний хангалт /хувиар/
1	Сүү	Тн	705.4	1,723.8	100.0%	705.4	1,641.8	100.0%
2	Мах	Тн	940.8	2,092.2	100.0%	940.8	1,987.4	100.0%
3	Төмс	Тн	510	100.6	15.2%	59.5	97.7	14.6%
4	Хүнсний ногоо	Тн	309	140.7	14.9%	115.5	117.2	12.3%
6	Өндөг	Мян.ш	2,520.0	525.0	20.8%	2,520.0	402.8	15.7%
	Дүн			4,582.3			2,459.5	

Хүснэгтээс харахад: 2016 онд уламжлалт аргаар тооцсон мах, сүүний хэрэгцээг бүрэн хангасан бол нийт хэрэгцээний өндөгний 15.7%-ийг, төмсний 14.6%-ийг, хүнсний ногооны 12.3%-ийг, 2017 онд мөн уламжлалт аргаар тооцсон мах, сүүний хэрэгцээг бүрэн хангасан ба дотоодын нийт хэрэгцээний өндөгний 20.8%-ийг, төмсний 15.2%-ийг, хүнсний ногооны 14.9%-ийг тус тус хангасан байна.

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 8 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор нийт 196 иргэнийг хамруулсан байна. Тухайлбал, аймгийн МХГ-тай хамтран “Эрүүл хүнс” сарын аяныг зохион байгуулж хүнсний үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний худалдаа эрхлэгч иргэн, ААН-ийн дунд 2 удаагийн сургалт, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хүнсний бүтээгдэхүүнээ хэрхэн зөв сонгох, хадгалах талаар” 3 удаа, ҮХААС-ын 2013 оны А/98 дугаар тушаалаар батлагдсан “Мал амьтан, ургамал тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох журам”-ыг таниулах, “Урагш нэг шат, хойш нэг шат” бүртгэлийн дэвтрийг нэвтрүүлэх” сургалтыг хүнсний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 24 ААНБ-д 2 удаа, сургууль, цэцэрлэгийн дэргэдэх цайны газарт “Зохистой дадал” нэвтрүүлэх сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Мөн “Хүнсний аюулгүй сав” дэд хөтөлбөрийн хүрээнд 2016 онд 7 ажил төлөвлөж, төлөвлөгөөний дагуу хүнсийг хадгалах, зөөвөрлөхөд өргөн ашигладаг сав баглаа боодлын хэрэглээнд судалгаа хийх, судалгааны дүнд үндэслэн хүнсэнд ашигладаг сав, баглаа боодлын зохистой хэрэглээ, тэмдэглэгээний талаарх зөвлөмжийг боловсруулж, аймгийн төвийн иргэдийн өргөнөөр үйлчлүүлдэг худалдааны төвүүдийн мэдээллийн самбарт байршуулсан, сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдийг гарын авлага, мэдээллээр хангасан, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төлөөлөлд хуванцар савны хэрэглээний талаар сургалт хийж 29 хүүхэд хамруулсан тухай ажлын тайланд тусгасан боловч дээрх хөтөлбөрийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө болон баталсан шийдвэр,


хуванцар савны хэрэглээнд хийсэн судалгаа, судалгааны дүн нь архивлагдаагүй, судалгааны дүн хэрхэн гарсан нь тодорхойгүй байна.

Сумдын МЭҮТ-ийн мэргэжилтнүүдэд хуванцар савны хэрэгээлний талаарх гарын авлага, мэдээллээр хангаж ажилласнаар 2016 онд Шивээговь суманд 1 сургалт зохион байгуулж 19 иргэн, 2017 онд Сүмбэр суманд 1 сурталчилгааны ажил, 4 сургалт зохион байгуулж нийт 304 иргэн, ААНБ-ыг тус тус хамруулсан байна.

- **Газар тариалангийн чиглэлээр** газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Аймгийн хэмжээнд газар тариалангийн эргэлтийн талбай 2016 онд 74,97 га байсан бол 2017 онд 76.5 га-д хүрч 1.53 га-гаар нэмэгдсэн байна. Энэ нь иргэн ААНБ-аас газрыг ашиглалтад оруулсан буюу хагалсан газрын талбайн хэмжээгээр нэмэгдсэн байна.

Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг өмнөх онтой харьцуулан графикаар харуулбал:



Графикаас харахад: газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт 2017 оны байдлаар өмнөх оноос 1,1-12.4 га-гаар буурч, өнжсөн талбайн хэмжээ 41,1 га-гаар өссөн нь 5 хүлэмж салхинд хийссэн, мөн 3 талбайн бүх тариалалт салхинд хийссэнээс дахин тариалалт хийгдсэн, мөн иргэдийн санхүүгийн боломжоос тус тус шалтгаалсан байна.

Аудитын явцад ГХБХБГ-аас газар тариалангийн чиглэлээр газар эзэмшиж буй иргэд, ААНБ-ын судалгааг гаргуулан авсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар газар тариалангийн зориулалтаар нийт 301.9 га газрыг олгосон байна. Гэтэл 2017 оны жилийн эцсийн байдлаар газар тариалангийн эргэлтийн талбай 76.5 га байгаа нь газар тариалангийн зориулалтаар олгосон газрын 25.3%-ийг эзэлж байна

Газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар газар эзэмшиж байгаа нийт 34 иргэн, 11 аж ахуй нэгж, 3 төрийн байгууллагын судалгааг авч үйл ажиллагаа явуулсан эсэхийг газар дээр нь очиж шалгахад Сүмбэр сумын 23 иргэн, Баянтал сумын 1 иргэн, Шивээговь сумын 3 иргэн, 4 ААНБ, 1 төрийн байгууллага нийт 32 иргэн, ААНБ өөрсдийн эзэмшлийн газарт тариалалт эрхлээгүй бөгөөд иргэд нь тус газартаа хашаа, малын саравч барьж мал маллаж, газрыг зориулалт бусаар ашигласан байна.

Энэ нь төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо муу, хамтран ажиллах талаар идэвхи санаачлагатай ажиллаагүйг харуулж байна.

Иймд аймгийн ГХБХБГ-тай ажлын уялдаа холбоогоо сайжруулах, газар тариалангийн зориулалтаар газар авсан иргэдтэй хамтран ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Өрхийн тариаланчдыг дэмжих зорилгоор ХХААЯ-наас 2016 онд хуваарилсан 937.5 мянган төгрөгийн 104 кг хүнсний ногооны үрийг 63 иргэнд, 2017 онд 710.0 мянган төгрөгийн 500 кг төмсний үрийг 15 иргэнд тус тус олгосон боловч хэдэн төрлийн хүнсний ногоог хэдэн га талбайд тариалсан талаар тайлан, мэдээ байхгүй, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

Сумдын 2016-2017 оны ургац хураалтын байдлыг нэр төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	2016 он /тн/				2017 он /тн/			
		Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Жимс жимсгэнэ
1	Сүмбэр	78.7	38.5	5.2	1.9	77,7	61,1	0,3	1,3
2	Баянтал	5.2	6.3	-	0.04	1,7	1,9	25,5	0,03
3	Шивээговь	13.8	72.5	-	-	21,2	77,7	2	0,07
	Дүн	97.7	117.3	5.2	2.02	100,6	140,8	27,8	1,4

Хүснэгтээс харахад: Өмнөх оныхоос төмс 2.86 тн, хүнсний ногоо 23.5 тн, тэжээлийн ургамал 22.64тн-оор тус тус нэмэгдэж, жимс жимсгэнэ 0.62 тн-оор буурсан байна. Энэ нь жимс жимсгэний тариалалт өмнөх оноос буурсантай холбоотой байна.

- **Хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, хоршоо, биржийн чиглэлээр** бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулах, худалдаа, үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодыг дэмжиж, орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжих, хөнгөлөлттэй зээлийн шинэчлэгдсэн журмыг сурталчлах, орон нутгийн хоршоодыг үнэлэх, хоршоодын үйл ажиллагааг идэвхижүүлэх, жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилтын дагуу 2016 онд аймгийн бизнес эрхлэгчдийн зөвлөгөөнийг АЗДТГ, Баялаг бүтээгчдийн холбооны салбар зөвлөл, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Говьсүмбэр салбар, “Дэлхийн Зөн” ОУБ-ын Бор-Өндөр 1 ОНХХ-тэй хамтран зохион байгуулж, нийт 127 төлөөлөгч оролцсон ба аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт худалдаа, үйлчилгээ, үйлдвэржилт, бизнес эрхлэлтийг дэмжих арга хэмжээний санал солилцож, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн байна.

Мөн “Үйлдвэрийн улсын тооллого”-ыг аймгийн хэмжээнд үйлдвэрлэл эрхэлж буй 23 ААНБ-ыг хамруулан зохион байгуулж, тооллогын дүн, мэдээллийг цахим санд /industry.mi.gov.mn/ байршуулсан ба 20 ААНБ бүртгэгдэж, 3 ААНБ нь бүртгэлийн шаардлагыг хангаагүй байна.

2017 онд Жижиг, дунд үйлдвэрийг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлгийг аймгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөлөл болсон 14 иргэнийг оролцуулан зохион байгуулсан байна. Аймгийн ХХААГ-аас санал хүргүүлж аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ХХААХҮС-ын 2017 оны А/89 тушаалаар, аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулсан байна.

АЗДТГ, ДЗМОУБ, СЗДТГ-тай хамтран орон нутгийн бизнес эрхлэгчид, малчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, сурталчлан таниулах, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, бизнесийн түншлэл тогтоох боломж олгох мөн нэг дороос хямд чанартай бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Элбэг дэлбэг цагаан сар” үзэсгэлэн худалдаа, иргэдэд үйлчлэх өдөрлөгийг тус тус зохион байгуулахад 2016 онд орон нутгийн 120 иргэн, бусад аймгийн 11 иргэн, 50 ААНБ оролцож 91,600.0 мянга, 2017 онд орон нутгийн 73 иргэн, бусад аймгийн 8 иргэн, 80 гаруй ААНБ оролцож 40,300.0 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Жил бүр Улаанбаатар хотод зохиогддог “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 2 иргэн 13 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 2016 онд 5,200.0 мянга, 2017 онд 7,200.0 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 24 хоршоо байгаагаас 16 нь үйл ажиллагаа явуулаагүй, 8 хоршоо тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. “ГСБЭХ” ХЗХ хоршоо,
2. “Тэвшийн хажуу ус” хоршоо – МАА, түүхий эд бэлтгэл, цагаан идээ,
3. “Сүмбэр айраг” хоршоо - эрчимжсэн МАА, газар тариалан,
4. “Оорцог элгэн” хоршоо - МАА, малын тэжээл тариалах,
5. “Говийн өндөр уул” хоршоо - Мах, махан бүтээгдэхүүн, байгалийн хадлан,
6. “Мөнхөд гэрэлтэх шүтээн” хоршоо – автомашин засвар, угаалга,
7. “Бидний жаргал” хоршоо – оёдол хувцас, засвар,
8. “Боржигон булаг” хоршоо – газар тариалан, үнээний ферм,

Орон нутгийн хоршоодыг үнэлэх, хоршоодын үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилтын дагуу аймгийн хоршоологчдын холбооны тэргүүлэгчдийн 2016 оны өргөтгөсөн хурлаар 2015 оны ажлын тайлан, 2016 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлж, хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан байна.

2016 оны аймгийн орон нутгийн хөгжил сангийн санхүүжилтээр хоршоодыг байртай болоход дэмжлэг үзүүлэх /9,500.0 мянга/, бүсийн чанартай үзэсгэлэн худалдаанд оролцуулах, туршлага судлуулах /500.0 мянга/ зорилгоор нийт 10,000.0 мянган төгрөгийг батлуулсан ба хариуцан ажилласан “Их буянт цагаан эсгий” хоршоонд 3,800.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон боловч хоршоодын байрны гүйцэтгэлийг хугацаанд нь аймгийн ОНХС-д гаргаж өгөөгүйгээс үлдэгдэл санхүүжилт олгогдоогүй, байр дутуу баригдаж, одоог хүртэл ашиглалтад ороогүй байна.

Говьсүмбэр аймгийн хоршоодын төлөөлөлд Канад-Монголын хоршоологчдын нэгдсэн холбооны төлөөллүүд “Хоршооны сургагч багш бэлтгэх сургалт”, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны гүйцэтгэх захирал “Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хоршоо хэрхэн хөгжих”, “Намас кооп”-ын захирал Батболд 4,000.0 мянга төгрөгийн дэмжлэг “Намас соор-ын үйл ажиллагаа”, “Хоршооны брэнд бүтээгдэхүүн”, хоршоодын талаар төрөөс баримталж буй бодлого” сэдэвт сургалтууд зохион байгуулсан байна.

Аймгийн ХАА-н хоршоологчдын холбооны 6 төлөөлөл Өмнөговь аймагт зохион байгуулагдан ХАА-н хоршоологчдын улсын зөвлөгөөнд оролцож Өмнөговь, Дорноговь, Дундговь, Төв, Хэнтий, Сүхбаатар, Дархан-уул, Орхон-уул, Сэлэнгэ, Булган аймгуудын хоршоологчдын төлөөлөлтэй ажлын арга туршлага солилцсон байна.

2017 онд “Инвест ко-оп Монгол” төслийн байгууллагатай хамтран хоршоологчид өрх толгойлсон эмэгтэйчүүд, хоршоодын гишүүдэд зориулсан 16 удаагийн уулзалт, сургалт, зөвлөх үйлчилгээ зохион байгуулж давхардсан тоогоор 553 иргэнийг хамруулсан бол “Хоршоодын бизнес түншлэл” хэлэлцүүлэг форумыг 5 аймгийн 10 хоршоодын дунд зохион байгуулсан байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2011-2015 онд аймгийн хэмжээнд Хаан банк, Хас банкаар 29 иргэнд 814,000.0 мянга, 4 аж ахуй нэгжид 260,000.0 мянга, нийт 1,074,000.0 мянган төгрөгийн зээлийг олгосон байна.

Зээлийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал /2018.05.31 байдлаар/

/мянган төгрөгөөр/

Д/д	Зээлдэгч	Тоо	Зээлийн үлдэгдэл
1	Иргэн	5	37,396.4
2	Аж ахуй нэгж	4	97,894.0
Нийт дүн		9	135,290.4

Хүснэгтээс харахад: Зээлийн үлдэгдэл бага байгаа нь тухайн зээл олгосон банкууд нь зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг зохистой хэрэгжүүлсэн, зээлийн хүү бага хувьтай байсан нь иргэд, ААНБ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, зээлээ цаг хугацаанд нь төлж барагдуулахад таатай нөлөө үзүүлсэн байна.

Нийт зээл авсан 29 иргэн, 4 аж ахуй нэгжээс 12 иргэн буюу 41.3%, 3 аж ахуй нэгж буюу 75% нь зээлээ зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бол 17 иргэн, 1 ААНБ үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй, зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь ХХААГ холбогдох банкуудаас зөвхөн зээлийн эргэн төлөлтийн мэдээг авч байсан ба зээлдэгчдийн үйл ажиллагаа, зээлийн зориулалтад хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.

Иймд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2. Мал аж ахуйн алба

Тус алба нь малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдийг болон сумдын тасаг, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд 2016 онд 15, 2017 онд 14 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2016 оны ажлын гүйцэтгэл 78.6%, 2017 оны ажлын гүйцэтгэл 80.0%-тай байна.

Аймгийн хэмжээнд мал сүрэг 2016 онд 4.8%, 2017 онд 10.2%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2016-2017 оны жилийн эцсийн малын тоо, өсөлтийн хувийг төрлөөр нь өмнөх онтой харьцуулан хүснэгтээр харуулбал:/тоо, толгой/

Д/д	Төрөл	2015	2016	Өсөлт, бууралт		2017	Өсөлт, бууралт	
				Тоо	%		Тоо	%
	Дүн	379,477	397,910	18,433	4,8	438,409	40,499	10,2
1	Тэмээ	869	822	-47	(5,4)	929	107	13,0
2	Адуу	18,149	20,250	2,101	11,6	22,271	2,021	10,0
3	Үхэр	12,390	13,646	1,256	10,1	14,903	1,257	9,2
4	Хонь	169,090	185,883	16,793	9,9	205,229	19,346	10,4
5	Ямаа	178,979	177,309	-1,670	(0,9)	195,077	17,768	10,0

Хүснэгтээс харахад: аймгийн хэмжээний нийт малын тоо 2016 онд өмнөх оноос 18,433 тоо, толгой буюу 4.8%, 2017 онд өмнөх оноос 40,499 тоо, толгой буюу 10.2%-иар тус тус өссөн байна. 2017 онд бүх мал 9.2-13.0%-иар тус тус өссөн бол 2016 онд малын тоо, толгой нийт дүнгээрээ өсөлттэй гарсан боловч 2 төрлийн мал буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, ямаа 0.9%, тэмээ 5.4%-иар тус тус буурсан байна.

2017 оны малын төллөлт, төлийн бойжилтыг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	2017	2016	Өсөлт, бууралт	Хувьоны
1	Оны эхний хээлтэгч	185,558	171,188	14,370	8,4
2	Төллөсөн хээлтэгч	171,461	151,504	19,957	13,2
3	Гарсан төл	173,054	152,690	20,364	13,3
4	Хорогдсон төл:	2,828	3,396	-568	(16,7)
	Үүнээс : Арьсанд бэлтгэсэн	242	316	-74	(23,4)
6	Бойжиж буй төл	170,226	149,294	20,932	14,0
7	Бойжилтын хувь	98,4	97,8	0,6	0,6
8	Төллөлтийн хувь	92,4	88,5	3,9	4,4

Хүснэгтээс харахад: 2017 онд өмнөх оны хээлтэгчийн тоо 8.4%, төллөсөн хээлтэгч 13.2%, гарсан төл 13.3%, бойжиж буй төл 14.0%, бойжилтын хувь 0.6%, төллөлтийн хувь 4.4%-иар тус тус өссөн ба хорогдсон төлийн тоо 16.7%, арьсанд бэлтгэсэн төлийн тоо 23.4%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд эх сүргээс ялгавал зохих хээлтүүлэгч 2016 онд 1875, 2017 онд 1916 байснаас 2016 онд 1170, 2017 онд 1624 хээлтүүлэгчийг тус тус ялгаж хээлтүүлгэнд оруулсан байна.

2017 онд сумдын мал сүргийн чанарыг сайжруулах, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог бүрдүүлэх зорилгоор “Инвест ко-оп Монгол” төслийн байгууллагатай хамтран ажилласнаар “Сүмбэр зоо” МҮТАҮНэгжээс Сүмбэр сумын “Тэвшийн хажуу-Ус” хоршоонд 5 хуцан хурга, 5 ухна ишиг, Баянтал суманд 10 хуцан хурга, 15 ухна ишиг нийлүүлэгдэж МҮТАҮНэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.

Баянтал сумын Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд ХХААХҮСайдын 2010 оны А/210 дугаар тушаалын дагуу сумынхаа бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь тусгайлан ялгаж хуц, ухна маллах нутаг бэлчээрийг сонгон, УТХО-аар гүн өрмийн худаг гаргуулж, мөн “Инвест ко-оп Монгол” төслийн хөрөнгөөр хашаа, хороо бариулах ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Нэгж малаас авах ашиг шимийн үзүүлэлтийг 2017 онд өмнөх оны төлөвлөгөөнөөс бууруулж төлөвлөсөн боловч гүйцэтгэл нь өмнөх оноос давсан байна.

Нэгж малаас авах ашиг шимийн гарцыг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2017 он		2016 он		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Цэвэр, эрлийз үнээний сүү	кг	167,2	157,1	341,2	140,0	(174,0)	17,10
2	Ноос	кг	1,20	1,20	1,20	1,50	-	(0,30)
3	Ноолуур	гр	0,450	0,488	0,420	0,486	0,030	0,002
	Дүн		168,9	158,8	342,8	142,0	(174,0)	16,8

Хүснэгтээс харахад 2017 онд ноолуурын гарцыг 7.1%-иар нэмэгдүүлж төлөвлөсөн бол цэвэр, эрлийз үнээний сүүний гарцыг 51.0%-иар бууруулж төлөвлөсөн байна. Энэ нь жилийн эцсийн малын тооллогоор эрлийз үнээний тоо буурсантай холбоотой байна. Гүйцэтгэлээр 2017 онд цэвэр, эрлийз үнээний сүүний гарц өмнөх оноос 12.2%, ноолуурын гарц 0.4%-иар тус тус нэмэгдсэн бол ноосны гарц 20.0%-иар буурсан нь хонийг цаг хугацаанд нь ноослоогүй, ноосоо хаясан хойно ноослож байгаатай холбоотой байна.

2017 онд Сүмбэр үүлдрийн нийт хонь 2154 толгойд хүрч өмнөх оноос 130 толгой буюу 6.0%-иар, үүнээс цэвэр үүлдрийн хонь 1521 болж урьд оноос 72 толгойгоор буюу 4.5%-иар буурсан байна. Мөн хөх 95, хар 121, хүрэн 22, зулбадай 4 нийт 242 арьс бэлтгэсэн ба арьсны борлуулалтаар 3,600.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

МАН-н алба нь малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, Орон нутагт зохицсон мал үржүүлэх бодлогын хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- 2016-2017 онд Сүмбэр, Барга, Үзэмчин, Баянцагаан үүлдрийн хонь, мах-сүүний чиглэлийн Шар тарлан, Алатау, махны чиглэлийн Лимузин, Ангус үхэр, ноолуурын чиглэлийн Баяндэлгэр, Буурал омог, Залаа жинстийн цагаан ямааг

сайжруулагчаар ашиглаж малын ашиг шимийн гарцыг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, дунджаар хонины амьдын жин 350-510 гр-аар, ноолуурын гарц 60-125 гр-аар тус тус нэмэгджээ.

- Ашиг, шимийн үзүүлэлтүүдийг урьд онтой харьцуулахад Баяндэлгэр үүлдэр, Буурал омгийн ямаагаар сайжруулж, ноолуурын гарц арвинтай нутгийн ямааг сонгон өөр дотор нь үржүүлснээр энэ онд Шивээговь сумын ноолуурын дундаж гарц 0.520 гр, Баянтал сумын ноолуурын дундаж гарц 0.453 гр хүрч, аймгийн дундаж гарц 0.486 болж урьд оноос 66 гр-аар нэмэгдсэн байна.
- Хонины үүлдрийг сайжруулах, махны гарцыг нэмэгдүүлэх зорилгоор Барга, Үзэмчин, Сүмбэр хонийг сайжруулагчаар ашиглаж, нийт хонины махны гарц сүүлийн жилүүдэд ХААҮС-ын 1999 оны А/117 дугаар тушаалаар батлагдсан журмын стандартаас 25.9 %-иар нэмэгдсэн байна.
- Сүмбэр, Барга, Үзэмчин үүлдэр, мөн мах-сүүний чиглэлийн шар тарлан, алатау, махны чиглэлийн Лимузин, Ангус, Сэлэнгэ, хосолмол ашиг шимт шар тарлан, КЦТ үүлдрийн болон эрлийз бухыг худалдан авч ашигласан байна. 2016 онд дээрхи үүлдэрүүдийн 236 үнээ, 22 бух үржүүлж байсан бол 2017 оны 12 сарын байдлаар 5 өрх сүүний чиглэлийн 315 үхэр үржүүлж эхэлсэн байна.
- Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, бодлогоор дэмжиж, гахай шувууны аж ахуйн тоог нэмэгдүүлнэ гэсэн зорилтын хүрээнд аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар цахилгаан татаж, худаг гаргасан эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт газар олгож гахай, тахиатай аж ахуй нэгж, иргэнийг бус нутагт төвлөрүүлэн суурьшуулахаар 11 иргэн, аж ахуйн нэгжид газар олгосон боловч тус бүсэд суурьшаагүйгээс тус газрын захирамжийг цуцалж, шинээр 6 иргэн аж ахуй нэгжид газар олгосон боловч одоогоор нэгч иргэн аж ахуй нэгж суурьшаагүйгээс хэрэгжүүлсэн ажил нь үр дүнгүй байна.

2016 онд Мал сүрэгт ангилалт хийсэн дүнгээр аймгийн хэмжээнд 2,144 адуу, 115 тэмээ, 1,185 үхэр, 9,085 хонь, 6,520 ямаа, нийт 19,049 малыг хамруулсан бөгөөд үүний 16,377 буюу 85.9 % нь шилмэл болон 1-р ангилалд багтсан бол 442 буюу ангилалт хийгдсэн нийт малын 2.3% нь зааз мал эзэлжээ.

2017 онд Мал сүрэгт ангилалт хянан баталгаажуулалт хийх ажлыг МЭҮГазрын даргын 2017 оны 05 сарын 25-ны өдрийн А/21 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны 06 сарын 08-ны өдрийн А/181 дугаар захирамж, ХХААГ-ын даргын 2017 оны 06 сарын 08-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийг үндэслэн “Мал ангилах заавар”-ын дагуу 2006-2013 онуудад мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээ эрхэлж байсан “Сүмбэр зоо” ХХК МҮТАҮН мал үржлийн үйл ажиллагаа явуулахаар Баянтал, Сүмбэр сумын Засаг даргатай гэрээ байгуулж 11,790 малд, шинээр байгуулагдсан “Сүмбэр хишигтэн зоо” ХХК МҮТАҮНэгж нь Шивээговь сумын Засаг даргатай гэрээ байгуулан 1,210 малд ангилалт хийсэн байна.

Ноосны урамшууллын талаар: 2016 онд хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий 295 этгээдийн 98.6 тн ноосонд 98,900.0 мянга, 2017 онд 291 өрхийн бэлтгэсэн 89,4 тн хонь, тэмээний ноос 90,20.0 мянга, мөн 2016 оны сүүлийн хагас жилд бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан арьс, ширний урамшуулалд 372 өрхийг хамруулан 167,000.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Худаг, уст цэг, бэлчээрийн усан хангамжийн хувьд: 2016 онд бэлчээрт нийт 8 худаг шинээр гаргаж, 2 худаг сэргээн засварласан байна. Тухайлбал, малчдын санаачилгаар 6 худгийг шинээр гаргаж, 1 худгийг сэргээн засварласнаас гадна ДЗОУБ-ын 7,500.0 мянган төгрөгийн хөрөнгөөр 1 худгийг сэргээн засварлаж, 2 гар худгийг шинээр гаргаж, нийт 10,500 га бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлсэн байна.

2017 онд нийт 12 худаг шинээр гаргаж ашиглалтад оруулсан байна. Тухайлбал, Сүмбэр суманд малчдын санаачлагаар энгийн уурхайн 6 худаг, инженерийн хийцтэй 1 худаг, УТХО-аар инженерийн хийцтэй 3 худаг, Сүмбэр сумын ЭМАА-н бүсэд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 1 худаг, Шивээговь суманд 1 иргэн өөрийн хөрөнгөөр газар тариаланд 1 инженерийн хийцтэй худаг тус тус шинээр гаргасан байна.

Аймгийн ХХААГ нь 2017 онд Усны сав газартай хамтран хийгдсэн бэлчээрийн усан хангамжийн судалгаагаар бэлчээрт нийт 315 худаг ашиглагдаж байгаа бөгөөд нийт бэлчээрийн 77.5% нь усжуулагдсан үзүүлэлттэй байна.

Бэлчээр хамгаалах, сайжруулах ажлын хүрээнд: 2016 онд Сүмбэр сумын 10,000 га-д бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажил хийгдсэн ба 2017 онд үлийн цагаан оготныг устгах ажлыг 1 ААН-ийн 2.4 га талбайд, Сүмбэр сум 17,000 га талбайд 85.0-97.0%-ийн техник үр дүнтэй хийлээ. Мөн Сүмбэр сумын 23,000 га, Шивээговь сумын 5,000 га талбайд үлийн цагаан оготны тандалтыг хийсэн байна. Тандалтын үр дүнгээр Шивээговь сум тэмцэх хэмжээнд хүрсэн боловч санхүүгийн хүндрэлээс шалтгаалан тэмцэх ажил хийгдээгүй байна. Харин 2018 онд аймгийн бэлчээрийн нийт талбайн 30% буюу 140.0 мян.га талбайд бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг хийх саналыг холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.

2017 онд аймгийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар, сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж ИТХТ-ийн хурлаар тус тус батлуулан ажилласан ба ХХААГ-аас сумдыг зөвлөгөө, мэдээлэл, гарын авлагаар хангаж ажилласнаас гадна бэлчээрийн менежментийг оновчтой зохион байгуулах, бэлчээрийг өтгөрүүлэх замаар даац багтаамжийг нэмэгдүүлэх арга туршлагыг малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүдэд эзэмшүүлэх, технологийн мэдлэг олгох зорилгоор Дэлхийн зөн ОУБ болон Сүмбэр сумын ЗДТГ-тай хамтран бэлчээр сайжруулах өтгөрүүлэх, бэлчээрийн менежментийн тухай ерөнхий ойлголт, бэлчээрийн даац, багтаамж, ачааллыг тооцох аргачлал, бэлчээрийн олон наст ургамал царгас тариалах технологи, үр хадгалах технологи, царгас тариалах технологийн талаар 6 цагийн мэдлэг олгох онолын болон 3 цагийн дадлагын сургалтыг Тэрэгтэд 0,25 га талбайд тариалалт хийж 40 малчин, 16 мэргэжилтэн, тариаланчдыг хамруулан зохион байгуулсан байна.

МАА-н 2016-2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай МУЗГ-ын 322-р тогтоол, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоолын дагуу бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна. Мөн 2017 онд аймгийн онцгой комиссыг хуралдуулан өвөлжилт хүндэрч болзошгүй Сүмбэр сумын 5,6 дугаар баг, Баянтал сумын 1,2 дугаар баг, ЦСҮТ зэрэг нийт 234 малчин өрхөд 2016 онд нөөцөлж өнжсөн 214 тн өвс, 12.8 тн тэжээлийг хөнгөлөлттэй үнээр борлуулах шийдвэрийг гаргуулж, малчдад нийлүүлсэн байна.

3. Мал эмнэлгийн алба

Малчид, мал бүхий иргэн, хуулийн этгээдийг болон сумдын тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх гэсэн үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.

Дээрх чиг үүргийн хүрээнд 2016 онд 3, 2017 онд 6 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2016 оны ажлын гүйцэтгэл 96.6%, 2017 оны ажлын гүйцэтгэл 95.0%-тай байна.

Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий 8 нэгж ажиллаж байна. 2016 онд нэг нэгж, нэг эмчид дунджаар 40.0-50.0 мянган толгой мал

ногдож байсан бол 2017 онд нэг нэгж, нэг эмчид дунджаар 50.0-54.0 мянган толгой мал ногдож өмнөх оноос 10.2%-иар өссөн нь малын тоо толгой өссөнтэй холбоотой байна.

Ужиг халдварт 13 төрлийн өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд 2016 онд 117.3 мянган толгой мал хамруулахаас 117.0 мянга, 2017 онд 97.0 мянган толгой мал, амьтан хамруулахаас 97.0 мянган толгой мал, амьтан хамруулж, гүйцэтгэл 99.7-100%-тай хамрагдсан байна.

Жил бүр гардаг шөвөг яр, сахуу, хордлогын шинжтэй өвчнүүдийн эсрэг вакциныг эпизоотологийн судалгаанд тулгуурлан хийж, вакцинжуулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулснаар 2017 онд орон нутгийн шинжтэй голомтот өвчин болох шөвөг яр, сахуу, ДХХ энтеробактериоз зэрэг өвчний гаралт өмнөх жилүүдээс эрс багасаж малчдаас гомдол гараагүй байна.

МЭАЦ-ийн ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээнд 2016 онд МАА-н гаралтай 69.0 мян.м² талбай хамруулахаас 309 цэгийн 93.1 мян.м² талбай, 2017 онд 69.1 мян.м² талбай хамруулахаас 323 цэгийн 63.4 мян.м² талбай хамруулж, гүйцэтгэлээр 91.0-135.0%-тай хийгдсэн байна.

Гоц халдварт шүлхий өвчний голомтыг устгах, халдварын тархалтыг таслан зогсоох, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлууд 2016 онд хийгдсэнээр халдваргүйжүүлэлтийн хувь хэмжээ 35%-иар давж биелсэн байна.

Лабораторийн төлөвлөгөөт оношлогоо шинжилгээнд 2016-2017 онд 7.1 мянган толгой мал хамруулахаас 7.0 мянган толгой мал хамруулсан байна. Үүнээс Бруцеллёзын төлөвлөгөөт шинжилгээнд 2.0 мянган толгой мал хамруулахаар төлөвлөж бүрэн хамруулжээ.

Шинжилгээний дүнгээр адууны ям, үхрийн сүрьеэ, боом, вирусын зулбах, цусан халдвар, дотрын халдварт хордлого зэрэг хяналтанд байдаг өвчнүүд илрээгүй байна.

Харин 2016 онд 1953 мал сөрөг, 47 мал эерэг дүн үзүүлж, шинжилгээнд хамрагдсан малд эзлэх бруцеллёзын өвчлөл 2.3%-тай байсан бол 2017 1969 мал сөрөг, 31 мал эерэг дүн үзүүлсэн байна. Энэ нь шинжилгээнд хамрагдсан малд эзлэх бруцеллёзын өвчлөл 1.6%-тай гарсан нь өмнөх оноос 0.7%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2016 онд Хүн амын хүнсний хэрэгцээнд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлдэг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын 33 өрхийн 366 малыг тандалт шинжилгээнд хамруулснаас 179 саалийн үнээнд бруцеллёз, сүрьеэгийн, 116 ямаа, 71 тэмээнд бруцеллёзын шинжилгээ тус тус хийсэн ба 16 мал эерэг, 350 мал сөрөг дүн үзүүлж, өвчлөл 4.3%-ийн үзүүлэлттэй гарсан байна. Сүрьеэгийн харшил сорилд хамрагдсан 179 саалийн үнээнд өвчлөл илрээгүй боловч Бруцеллёзын шинжилгээгээр эерэг дүн үзүүлсэн 25 өрхийн 63 толгой малыг “Бруцеллёз өвчинтэй тэмцэх заавар”-ын дагуу нядалж өрхийн дотоодын хэрэгцээнд хэрэглэх талаар зөвлөмж өгч ажилласан байна.


2017 онд 12 өрхийн 679 малыг бруцеллёзын тандалт шинжилгээнд хамруулахад 7 мал эерэг, 672 мал сөрөг дүн үзүүлж, өвчлөл 1.03% гарсан ба өвчлөлийн хувь хэмжээ өмнөх оноос 3.2%-иар буурсан үзүүлэлттэй байна. Харин шинжилгээний дүнгээр эерэг дүн үзүүлсэн 2 өрхийн 7 толгой малыг “Бруцеллёз өвчинтэй тэмцэх заавар”-ын дагуу нядалж өрхийн дотоодын хэрэгцээнд хэрэглэх зөвлөмж өгсөн байна.

Нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 2016 онд малаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 21 цэгийн махны 64, сүүний 241, арьс ширний 58, ноос, ноолуурын 160, өндөгний 104 сорьцонд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж, 49.9 тн мах, 19.3 тн сүү, 32.8 тн ноос ноолуур, 2.0 мянган ширхэг өндөг, 27.4 мянган ширхэг арьс ширийг баталгаажуулахад магадлан шинжилгээний дүнгээр сүүний 5, өндөгний 53ш, нийт 58ш дээж стандартын шаардлага хангаагүй тул худалдаалахыг хориглосон байна.

Мөн 2017 онд мал, амьтнаас гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний магадлан шинжилгээг 430 сорьцонд хийхээр төлөвлөснөөс 344 сорьцонд хийсэн байна. Үүнд: Махны 158 сорьцонд шинжилгээ хийж 7,791 кг мах, сүүний 15 сорьцонд шинжилгээ хийж 17,050 л сүү, өндөгний 132 сорьцонд шинжилгээ хийж 18,540 ширхэг өндөг, боомын үүсгэгч илрүүлэх шинжилгээнд ноолуурын 8 сорьц хамруулж 190 кг ноолуур, арьс ширний 31 сорьц хамруулж, 190 ширхэг арьс ширийг тус тус баталгаажуулж хяналтанд авч ажилласан ба эдгээрээс өндөгний 15 дээж хүнсний шаардлагад нийцээгүй байна.

1.2 Салбарын бодлого, чиглэлийг баримтлан орон тооны дээд хязгаарт нийцүүлэн бүтэц, орон тоог баталсан байна.

ХХААХҮС-ын 2016 оны 01/1497 тоот удирдамжийн дагуу тус газрын бүтэц, зохион байгуулалтын ерөнхий бүтцийг дараахь байдлаар баталсан байна.



Дээрх удирдамжид аймгуудын Хүнс хөдөө аж ахуйн газрын бүтэц, зохион байгуулалтыг нийт 25 орон тоотой байхаар тусгасан боловч Говьсүмбэр аймагт 15 орон тоотой ажиллахаар баталсан байна.

Орон тооны бүтцийг хүснэгтээр харуулбал

Д/д	Нэгж албаны нэр	Батлагдвал зохих орон тоо	ХХААХҮЯ-наас баталсан
1	Газрын дарга	1	1
2	Нийтлэг үйлчилгээний мэргэжилтэн, ажилтнууд	5	4
3	Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний алба	4	3
4	Мал аж ахуйн алба	5	3
5	Мал эмнэлгийн алба	4	2
6	Лаборатори	6	2
Нийт		25	15

Хүснэгтээс харахад: ХХААХҮС-ын 2016 оны 01/1497 тоот удирдамжийн дагуу тус газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг батлахдаа Албаны дарга нар тус нэгжийн чиг үүргийн аль нэг асуудлыг давхар хариуцах, Лабораторийн эрхлэгч нь зарим аймагт нян судлаач эмчийн ажлыг хавсарч гүйцэтгэнэ гэж зааснаар 6 орон тоог дутуу буюу бусад мэргэжилтнүүд 1-3 ажлыг хавсарч гүйцэтгэхээр баталсан байна.

Батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан 7 хүн дараах 9 орон тоог хавсран ажилласан байна. Үүнд:

1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний албаны дарга нь газар тариалангийн үйлдвэрлэл, технологи хариуцсан мэргэжилтэнг,
2. Мал аж ахуйн албаны дарга нь Уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл, үржүүлэг, технологи үйлчилгээний нэгжийн асуудал хариуцсан болон Малын генетик нөөцийн бүртгэл, менежмент, маркетинг, мэдээллийн сан, сүлжээ, тасаг хариуцсан мэргэжилтэнг
3. Малын бэлчээр, тэжээл, усан хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл, үржүүлэг, технологийн асуудал, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнг
4. Халдварт өвчин, тархвар судлалын асуудал хариуцсан мэргэжилтэн нь Паразит, халдваргүй өвчин, тасаг нэгж мэдээлэл хариуцсан мэргэжилтэнг
5. Ариун цэвэр, магадлан шинжилгээний эмч нь Нян судлаач эмч болон Малын эм, биобэлдмэл, эмийн сан, ариутгал, халдваргүйтэл хариуцсан мэргэжилтэнг
6. Лаборатори эрхлэгч нь Ийлдэс судлаач эмчийг
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн нь хүний нөөц, сургалт, тайлан, мэдээ хариуцсан мэргэжилтэнг тус тус хавсран гүйцэтгэж байна.

Мөн дээрх удирдамжийн дагуу тус газрын бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт үйлчлэгч, манаачийн орон тоо батлагдаагүй тул аймгийн Засаг даргын 2016 оны А/375 дугаар захирамжаар аймгийн ХХААГ-ын газрын бүтэц, орон тоог 15-аар батлахдаа Нийтлэг үйлчилгээний албанд үйлчлэгч манаачийн орон тоог 1-ээр нэмэгдүүлж, Мал аж ахуйн албаны орон тоог 1-ээр бууруулж баталсан байна.


Тус газар нь албан конторын барилга, ажилчдын орон сууцны барилгатай тул үйлчлэгч, манаачийн орон тоог батлуулах шаардлагатай байна.

Иймд орон тооны дээд хязгаарт нийцүүлэн үйлчлэгч, манаачийн орон тоог батлуулах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.3 Ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй ажилтныг авч ажиллуулсан, ажлын байрны сул орон тоо нөхөгдөөгүй байна.

Тус газарт нийт 15 албан хаагч ажиллаж байна. Үүнээс: төрийн захиргааны албан хаагч 9, төрийн үйлчилгээний албан хаагч 6 байна.

Ажилчдын боловсролын түвшин диаграммаар харуулбал



Аудитын явцад ажилчдын ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг тулган баталгаажуулахад 2 ажилтан шаардлага хангаагүй байна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, бирж, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байранд Хүнс, хөнгөн үйлдвэрийн менежмент, инженер, технологич, эдийн засагч мэргэжилтэй хүнийг ажиллуулах шаардлага тавьсан боловч ОУ-ын болон гадаад харилцааны мэргэжилтэй хүнийг
- Нягтлан бодогчийн ажлын байранд нягтлан бодогч мэргэжилтэй хүнийг ажиллуулах шаардлага тавьсан боловч санхүүгийн менежмент мэргэжилтэй хүмүүсийг тус тус ажиллуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг зөрчсөн байна.

Иймд ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтан авч ажиллуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн тус газарт дараах 4 ажлын байранд ажилтныг түр хугацаагаар ажиллуулж байна. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэр, хоршоо, бирж, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
2. Малын бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн
3. Халдварт өвчин, тархвар судлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
4. Мал аж ахуйн албаны дарга

Энэ нь сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж нээлттэй зарласан боловч тухайн орон тоонд ажилтан тэнцээгүйтэй холбоотой байна.

Иймд аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд сул орон тооны захиалгаа өгч, төрийн албаны нөөцөөс болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдээс орон тоог нөхөж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.4 Үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх талаар идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2016-2017 онд төсвийн хэмнэлттэй, үндсэн үйл ажиллагааны орлогыг шинжилгээний, ариутгалын, мал худалдсаны, ноолуурын зэрэг орлогуудаар бүрдүүлж, өөрийн орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлсэн байна.

Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээнд мөрдөх үнэ тариф болон түрээсийн төлбөрийн хэмжээг баталсан боловч үйл ажиллагааны зардлаа 100% улсын төсвөөс авч, орлогын төлөвлөгөө жил бүр тогтмол дүнгээр баталсантай холбоотой үндсэн чиг үүрэгт хамаарч буй бусад ажил үйлчилгээнээс орлого олох нөхцөл боломжийг судлаагүй, идэвх санаачлагатай ажиллаагүй байна.

Иймд бусад ажил үйлчилгээнээс орлого олох боломжийг судалж орлогын төлөвлөгөөг жил бүр нэмэгдүүлж баталж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Бүлэг 2

Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчсөн байна.

2.1. Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, тооцоолол хангалтгүй байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дараа оны төсвийн төслийг жил бүр Төсвийн тухай хуулийн дагуу боловсруулж хугацаанд нь хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг боловсруулахдаа 2014 оноос хойш төрөөс төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнээр бараа үйлчилгээний зардлыг өмнөх оны түвшинд барих, хөрөнгө бэлтгэхэд зардал төлөвлөхгүй байх зэрэг төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлогыг баримтлаагүй, жил бүр бараа, үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2016 оны төсвийн зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 32.7% буюу 48,103.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 195,253.2 мянга, 2017 оны төсвийг өмнөх оны гүйцэтгэлээс 38.3% буюу 62,607.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 226,214.5 мянган төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

2016-2017 оны төсвийн зарлагын төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	2015 оны Төсвийн гүйцэтгэл	2016 он				2016 оны Төсвийн гүйцэтгэл	2017 он		
			Төсвийн санал	Өмнөх оноос нэмэгдүүлсэн /-/, бууруулсан /+/ Дүн Хувь		Төсвийн санал		Өмнөх оноос нэмэгдүүлсэн /-/, бууруулсан /+/ Дүн Хувь		
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	112,742.0	138,928.0	-26,186.0	-23.2	115,254.3	146,401.1	-31,146.8	-27.0	
2	Ажил олгогчоос төлөх НДШ	12,401.5	15,461.8	-3,060.3	-24.7	27,555.4	16,104.1	11,451.3	41.6	
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,188.5	9,553.2	-1,364.7	-16.7	9,311.0	10,028.5	-717.5	-7.7	
4	Хангамж бараа материалын зардал	3,108.0	10,611.7	-7,503.7	-241.4	4,934.2	8,852.7	-3,918.5	-79.4	
5	Нормативт зардал	1,219.3	2,400.0	-1,180.7	-96.8	1,567.8	2,600.0	-1,032.2	-65.8	
6	Тавилга, эд хогшил худалдан авах зардал	1,001.6	6,419.0	-5,417.4	-540.9	618.0	26,521.0	-25,903.0	-4,191.4	
7	Томилолт зочны зардал	1,492.8	5,162.5	-3,669.7	-245.8	1,461.6	3,800.0	-2,338.4	-160.0	
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,301.0	2,143.0	-842.0	-64.7	2,604.7	2,128.9	475.8	18.3	
9	Бараа үйлчилгээний бусад зардал	100.0	2,512.0	-2,412.0	-2412.0	300.0	4,478.2	-4,178.2	-1,392.7	
10	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшууллын зардал	5,595.4	2,062.0	3,533.4	63.1		5,300.0	-5,300.0		
НИЙТ ДҮН		147,150.1	195,253.2	-48,103.1	-32.7	163,607.0	226,214.5	-62,607.5	-38.3	

Хүснэгтээс харахад: Цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 2016 онд өмнөх оны гүйцэтгэлээс 23.2% буюу 26,186.0 мянга, 2017 онд өмнөх оны гүйцэтгэлээс 27% буюу 31,146.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь үйлчлэгчийн цалин, ажилтнуудын цалингийн сүлжээний шатлал, зэрэглэл удаан жил, зэрэг дэвийн нэмэгдлийг нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Бараа үйлчилгээний зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 2016 онд 14.9% буюу 21,917.1 мянга, 2017 онд 19.2% буюу 31,460.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн нь бүх шатны төсвийн үр ашигтай, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор төрөөс баримталж байгаа бодлого, тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжийн дагуу төлөвлөөгүй байна. Тухайлбал: Шуудан холбооны зардалд үүрэн телефоны зардлыг нэмэгдүүлж төлөвлөсөн нь УИХ-ын 2016 оны 47-р тогтоолын 1.В.2 дахь заалттай нийцээгүй байна.

Мөн тайлант жилийн ХБГ болон өмнөх онуудын гүйцэтгэлд харьцуулалт хийгдээгүй, статистик тоо мэдээнд үндэслэдэггүй, судалгаа шинжилгээ хангалтгүй, байна.

Төсвийн төслийг батлагдсан маягтын дагуу төсвийн төсөөллийн хамт боловсруулдаг боловч төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, тооцоолол хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалтуудтай нийцээгүй байна.

2.2. Орлогыг нэр төрлөөр нь төлөвлөөгүй, орлогыг төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн үйл ажиллагааны орлого нь дараах орлогуудаас бүрдэж байна. Үүнд:

1. Түрээсийн орлого
2. Шинжилгээний орлого
3. Ариутгалын орлого
4. Мал худалдсаны орлого
5. Ноолуурын орлого

Тус газар нь 2016-2017 онд үндсэн үйл ажиллагааны орлогод 1,500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс 2016-2017 онд 1,500.0 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн байна.

Сүүлийн 2 жилийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Орлогын нэр төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	2016 он		2017 он	
			Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
1	Түрээсийн орлого			1,272.1		562.8
2	Шинжилгээний орлого			767.7		723.8
3	Ариутгалын орлого		1,500.0		1,500.0	75.0
4	Малын худалдсаны орлого			336.0		130.0
5	Ноолуурын орлого					75.1
Нийт дүн		2,399.5	1,500.0	2,375.8	1,500.0	1,566.7

/мянган төгрөг/

Хүснэгтээс харахад: Үндсэн үйл ажиллагааны орлогод гүйцэтгэлээр 2015 онд 2,399.5 мянга, 2016 онд 2,375.8 мянга, 2017 онд 1,566.7 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн бөгөөд 4.4-58.3%-иар давж биелсэн байна.

Орлогыг төлөвлөхдөө суурь судалгаагүй, орлогыг нэр төрлөөр нь төлөвлөөгүй, жил бүр тогтмол дүнгээр буюу нийт 1,500.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Харин орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь буюу 5 нэр, төрлийн орлого бүртгэсэн байна.

Орлогыг бодитой төлөвлөснөөр байгууллагын үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдэх боломжтой юм.

Иймд үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр, төрлөөр нь бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл зэргийг харгалзан үнэн зөв тооцож, төлөвлөж, батлуулж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3. Төсвийн зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчиж, цалингийн зардлаас тэтгэмж олгосон байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2016 онд 164,563.4 мянга, 2017 онд 165,055.8 мянган төгрөг зарцуулахаар батлагдаж, 2016-2017 оны төсөвт тус бүр 1 удаа тодотгол хийж, 2016 онд 163,607.0 мянга, 2017 онд 162,640.4 мянган төгрөг тус тус болж төсөв 17,330-28,211.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2016-2017 оны батлагдсан болон тодотгосон төсвийг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2016 он		Зөрүү	Хувь	2017 он		Зөрүү	Хувь
	Батлагдсан төсөв	Тодотгосон			Батлагдсан төсөв	Тодотгосон		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	136,351.7	164,563.4	(28,211.7)	(20.7)	147,725.8	165,055.8	(17,330.0)	(11.7)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,245.1	115,254.3	(8,009.2)	(7.5)	117,089.5	121,389.5	(4,300.0)	(3.7)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,797.1	27,687.1	(15,890.0)	(134.7)	12,880.0	13,380.0	(500.0)	(3.9)
Тогтмол зардал	6,118.9	9,318.9	(3,200.0)	(52.3)	6,420.2	9,850.2	(3,430.0)	(53.4)
Хангамж, бараа материалын зардал	3,458.1	4,934.3	(1,476.2)	(42.7)	3,792.7	4,742.7	(950.0)	(25.0)
Нормативт зардал	1,568.0	1,568.0	-	-	1,552.3	1,552.3	-	-
Эд хогшил худалдан авах	1,869.7	803.4	1,066.3	57.0	841.2	1,635.2	(794.0)	(94.4)
Дотоод албан томилолт	1,995.4	1,917.4	78.0	3.9	1,652.2	2,352.2	(700.0)	(42.4)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,394.0	2,779.5	(1,385.5)	(99.4)	1,787.3	4,243.3	(2,456.0)	(137.4)
Бараа үйлчилгээний бусад зардал	905.4	300.5	604.9	66.8	210.4	210.4	-	-
Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал			-		1,500.0	5,700.0	(4,200.0)	(280.0)

Хүснэгтээс харахад: Батлагдсан төсвийг 2016-2017 онд 11.7%-20.7%-иар тус тус нэмэгдүүлэн тодотгосон байна. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос

нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал, тогтмол зардлын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ.

Батлагдсан төсвийг тодотгосон шалтгаан нөхцлийг авч үзвэл:

1. 2015 онд цалинг хассантай холбоотойгоор 2015 оны санхүүгийн тайланд НД-ын байгууллагад 5,149.6 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнасан байна.
2. 2016 оны төсөвт цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг орон тоо хасагдаагүй байхад өмнөх оны гүйцэтгэлээс 5,496.9 мянган төгрөгөөр хасч баталснаас 2016 оны 10 дугаар сарын байдлаар НД-ын байгууллагад төлөх НДШ-ийн өр 13,454.6 мянган төгрөгт хүрсэн байна.
3. 2017 оны төсөвт цалингийн зардлыг 4,300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь ажлаас халагдсан албан хаагчид цалингийн зардлаас тэтгэмж олгосон, 3 албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг олгосон, үйлчлэгч ажиллуулсантай холбоотой байна.
4. Аймгийн ЭХЗЗ-ийн 2014 оны 09 тоот тогтоолоор халаалтын үнэ тариф нэмэгдсэн бөгөөд 2016-2017 онд түлш халаалтын зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 2,265.7-2,452.2 мянган төгрөгөөр хасч баталсан байна.

Дээрх нөхцөл шалтгааны улмаас төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага үүсч цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардал, түлш халаалтын зардал, тэтгэмж урамшууллын зардалд тодотгол хийсэн байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийг шат шатандаа үндэслэлгүй хянаж, баталдагтай холбоотой байна.

2016 онд 163,607.0 мянга, 2017 онд 165,055.8 мянган төгрөгийн төсвийг бүрэн хүлээн авч 2016 онд орлогоос 875.8 мянга, санхүүжилтаас 956.4 мянга нийт 1,842.2 мянга, 2017 онд орлогоос 66.6 мянга, санхүүжилтаас 2,415.5 мянга нийт 2,482.1 мянган төгрөгийн улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2016-2017 оны батлагдсан төсөв гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2016				2017			
	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	164,563.4	163,607.0	956.4	0.6	165,055.8	162,640.3	2,415.5	1.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,254.3	115,254.3	-	-	121,389.5	120,160.7	1,228.8	1.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,687.1	27,555.4	131.7	0.5	13,380.0	13,380.0	-	-
Тогтмол зардал	9,318.9	9,311.0	7.9	0.1	9,850.2	8,694.4	1,155.8	11.7
Хангамж, бараа материалын зардал	4,934.3	4,934.2	0.1	0.0	4,742.7	4,742.6	0.1	0.0
Нормативт зардал	1,568.0	1,567.8	0.2	0.0	1,552.3	1,552.2	0.1	0.0
Эд хогшил худалдан авах	803.4	618.0	185.4	23.1	1,635.2	1,635.2	-	-
Дотоод албан томилолт	1,917.4	1,461.6	455.8	23.8	2,352.2	2,327.3	24.9	1.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,779.5	2,604.7	174.8	6.3	4,243.3	4,243.2	0.1	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	300.5	300.0	0.5	0.2	210.4	204.7	5.7	2.7
Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал			-		5,700.0	5,700.0	-	-

Хүснэгтээс харахад: Төсвийн гүйцэтгэл 2016 онд 99.4%, 2017 онд 98.5% байна. 2017 оны төсөвт ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал өмнөх оноос 14,307.1 мянган төгрөгөөр буурсан нь 2015-2016 онд үүссэн өр төлбөр барагдуулсан шалтгаантай бөгөөд 2017 онд ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 5,700.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 1,463.8 мянга, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 6,135.2 мянган төгрөгийг төсөвтөө зохицуулалт хийн зарцуулсан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц сан, Мал эмнэлэг үржлийн газар, НҮБ-ийн ХХААГ, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори зэрэг газруудаас Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 2016 онд 145,554.8 мянга, 2017 онд 175,121.8 мянга, нийт 320,676.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аудитаар тус байгууллагын анхан шатны баримт материалыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2017 оны Б/02 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн захиргаа удирдлагын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ш.Дарханбатад цалингийн зардлаас 1,882.4 мянган төгрөгийн тэтгэмж олгожээ.
2. 2016 онд 286.2 мянга, 2017 онд 240.0 мянга нийт 526.2 мянган төгрөгийг цалин сангийн тооцоо төлөвлөгөөнд оруулаагүй боловч ахмадын санд зарцуулжээ.
3. Байгууллагын ахлах нягтлан бодогч А.Отгонтуяагийн цалин хөлсийг буруу тогтоосноос 2016 онд 344.9 мянга, 2017 онд 252.1 мянга, нийт 594.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын 7.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2017 оны цалингийн зөрүүг нөхөн олгох төлбөрийн акт тогтоогдсон байх тул 2016 оны цалингийн зөрүү 344.9 мянган төгрөгийг А.Отгонтуяад нөхөн олгуулах төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.4. Үйлчилгээний болон тарилгын хөлсний үнэ тарифыг эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрээр батлуулж, баримталж ажилласан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн ажил үйлчилгээ болох мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний үнэ тарифыг Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.1-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2015 оны 28 дугаар тогтоолоор Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээнд мөрдөх үнэ тарифыг батлуулсан байна.

Мөн түрээсийн төлбөрийн үнийг аймгийн ИТХ-ын 2013 оны 29 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд түрээсийн орон сууц түрээслэх гэрээ байгуулахдаа уг үнэ тарифыг мөрдөж ажиллажээ.

Уг тогтоолд Мал эмнэлгийн ажил үйлчилгээ, мал аж ахуй, үржлийн ажил үйлчилгээнд мөрдөх 12 төрлийн 218 ажил үйлчилгээний үнэ тарифыг багтаасан бөгөөд

тус байгууллага нь өндөг, мах, сүү, арьс шир, ноолуурын шинжилгээнээс 2016 онд 767.7 мянга, 2017 онд 723.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснийг данс бүртгэлд тусгасан байна.

Мөн тарилгын хөлсийг дээрх тогтоолоор бод мал 200, бог мал 150 төгрөгөөр тогтоож 2016 онд 869,102 бог, 33,246 бод малыг 3 төрлийн тарилгад 6 удаа хамруулж 137,014.5 мянга, 2017 онд 961,703 бог, 30,206 бод малыг 3 төрлийн тарилгад 6 удаа хамруулж 150,089.4 мянган төгрөгийн тарилгын хөлсийг тус тус тооцож олгожээ.

Тарилгын хөлсөнд зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

/төгрөгөөр/

Арга хэмжээ	Мал	2016			2017		
		Тоо	Тарилгын үнэ	Дүн	Тоо	Тарилгын үнэ	Дүн
Бруцеллёзоос урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын тарилга	Бог	188,244	150	729,200	103,685	150	15,552,750
	Бод	3,646	200	28,236,600	989	200	197,800
Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт	Бог	219,958	150	32,993,700	299,861	150	44,979,150
Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга	Бог	460,900	150	69,135,000	558,157	150	83,516,300
	Бод	29,600	200	5,920,000	29,217	200	5,843,400
Нийт		902,348		137,014,500	991,909		150,089,400

Хүснэгтээс харахад: Тус байгууллага нь Мал эмнэлэг, үржлийн газар, НҮБ-ийн ХХААГ-ын санхүүжилтээр давхардсан тоогоор 2016 онд 902.3 мянган толгой, 2017 онд 991.9 мянга, нийт 1,894.2 мянган толгой бог, бод малыг Шүлхий, бруцеллёз, хонины цэцэг өвчний вакцинд хамруулж тарилгын хөлсөнд нийт 287,103.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Ажил үйлчилгээ, тарилгын хөлсийг АИТХ-ын 2015 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан үнэ тарифын дагуу үнэн зөв тооцож олгосон байна.

Тарилгын хөлсийг олгохдоо Мал эмнэлэг, үржлийн газраас ирүүлсэн тайланг ХХААГ-ын дотоод хяналт, аймгийн МХГ-ын улсын байцаагч нараар хянуулан эцсийн байдлаар баталгаажуулан олгож ирсэн байна.

Малын халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд зориулж аймгийн ОНХС-д 2016 онд 22,087.3 мянга, 2017 онд 16,826.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 2016 онд 19,765.3 мянга, 2017 онд 16,826.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Малын халдварт өвчнөөс эмчилэн сэргийлэх ажлын гүйцэтгэсэн мал эмнэлгийн нэгжийн хүснэгтээр харуулбал

/мянган төгрөг/

Д/д	Мал эмнэлгийн нэгжийн нэр	Он	Нэхэмжилсэн үйлчилгээний хөлс	Олгосон санхүүжилт	Хасагдсан	Малчин өрхийн тамга дарагдаагүй олгосон ажлын хөлс
1	Уранхэрлэн ХХК	2016	2,918.9	2,918.9	0.0	577.2
		2017	2,514.1	2,501.4	12.7	237.2
2	Чинцолмон ХХК	2016	2,197.0	2,137.4	59.6	75.8
		2017	2,298.4	2,247.8	50.6	67.5

3	Аравжих баян эрдэнэ ХХК	2016	1,422.9	1,398.5	24.4	294.4
		2017	1,520.6	1,431.7	88.8	101.9
4	Би Си Ай ЭС ХХК	2016	2,121.1	2,059.7	61.4	731.7
		2017	1,779.8	1,762.3	17.5	172.7
5	Хөдөлмөрийн-Оч ХХК	2016	3,637.1	3,593.1	44.0	773.6
		2017	1,765.0	1,752.4	12.6	696.1
6	Амгена ББН	2016	2,177.6	2,157.0	20.6	346.7
		2017	2,241.2	2,231.5	9.6	246.2
7	Хилийн дэлгэрэх ХХК	2016	3,493.4	3,486.8	6.6	538.5
		2017	2,528.2	2,528.2	0.0	75.2
8	Дээр ХХК	2016	2,034.4	2,014.0	20.4	323.5
		2017	1,819.6	1,800.0	19.6	439.4
9	Чойр таван эрдэнэ ХХК	2016			0.0	
		2017	593.3	571.1	22.2	119.9
Нийт дүн		2016	20,002.4	19,765.4	237.0	3,661.3
		2017	17,060.1	16,826.5	233.6	2,156.0

Хүснэгтээс харахад: Нийт нэхэмжилсэн дүнгээс 2016 онд 237.0 мянга, 2017 онд 233.6 мянган төгрөг хасагдаж мал эмнэлгийн нэгжид олгогдсон нь батлагдсан төсөв хэтрүүлсэн болон эмчлэх тунгаар тарих малыг сэргийлэх тунгаар тарьсан зэрэг зөрчлүүд ХХААГ-ын Мал эмнэлгийн албаны даргын хяналтаар илэрч хасагдсан байна.

Харин Малчин өрхийн тамга дарагдаагүй олгосон тарилгын хөлс 2016 онд 3,661.3 мянга, 2017 онд 2,156.0 болж 41%-иар буурсан боловч тухайн зөрчил арилаагүй байна. Энэ нь Мал бүхий иргэд болон шинээр малчин болсон айлууд тамга аваагүйтэй холбоотой байна.

2.5. Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнасан байна.

ХХААГ нь 2016 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 163,063.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,500.0 мянга, 2017 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 163,555.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,500.0 мянган төгрөгийн орлого санхүүжилтын төлөвлөгөө батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 2016 онд санхүүжилт 163,063.4 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 2,375.8 мянга, 2017 онд санхүүжилт 163,555.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1,566.7 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 2017 оны санхүүгийн тайлангаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил дутагдал илэрчээ.

- 2 ажилтанд нийт 331.7 мянган төгрөгийн цалинг, ээлжийн амралттай давхардуулан олгосон.
- Нас дэвшүүлсэн болон худалдсан малыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Ажилчдын цалингаас сахилгн арга хэмжээнд 423.0 мянган төгрөг суутгасан боловч суутгалын хэмжээгээр цалин зардлыг бууруулсан.
- Цалин сангаас 240.0 мянган төгрөгийг ахмадын хүлээн авалт хийж зориулалт бусаар зарцуулсан.
- Нягтлан бодогчийн цалинг үндэслэлгүй бууруулсан зэрэг алдаа зөрчлүүд илэрч аудитын явцад 1,111.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 331.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 492.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч шийдвэрлэжээ.

Санхүүжилт, орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Орлого, санхүүжилтын нэр төрөл	2016 он				2017 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	163,063.4	163,063.4	(0.0)	(0.0)	163,555.8	163,555.8	-	-
2	Түрээсийн орлого	1,500.0	1,272.1	-875.8	58.4	1,500.0	562.8	66.7	4.4
3	Шинжилгээний орлого		767.7				723.8		
4	Ариутгалын орлого						75.0		
5	Малын худалдсаны орлого		336.0				130.0		
6	Ноолуурын орлого						75.1		
	Нийт		164,563.4				165,439.2		

Хүснэгтээс харахад: 2016-2017 онд санхүүжилтийг бүрэн авсан ба орлогын төлөвлөгөөг 2016 онд 58.4% 2017 онд 4.4%-иар тус тус давуулан биелүүлсэн байна.

2016-2017 онд улсын төсвөөс 326,619.2 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,942.5 мянган төгрөгийг хүлээн авч үнэн зөв бүртгэж тайлагнасан байна.

Орлогын бүртгэл тайлагналтай холбоотой анхан шатны баримт материалыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шинжилгээний төлбөрийг касст бэлнээр хүлээн авч төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлдэг бөгөөд ингэхдээ банкны үйлчилгээний шимтгэлд төлсөн мөнгийг орлого, зардлаар тайлагнаагүй байна.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай байгуулсан 2016 оны өмч эзэмшлийн гэрээнд түрээсийн орлогын 20%, 2017 оны гэрээнд түрээсийн орлогын 30%-ийг төвлөрүүлэх үүрэг хүлээсэн байна. Гэрээний үүргийг 2016 онд 81.2 мянган төгрөгөөр дутуу биелүүлжээ.

Дээрх зөрчил нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээ зүйлийн 14.4.5, 14.4.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

“ХХААГ”-ын 2017 оны санхүүгийн тайланд 198.3 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн бөгөөд өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Оны эхэнд 230.8 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн бөгөөд авлага буурсан шалтгаан нь ХХАОТ-ын авлага 32.8 мянган төгрөгөөр буурч, ажиллагсдаас авах авлага 0.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

2017 оны жилийн эцсийн тайланд тусгагдсан авлагыг насжилтаар нь харуулбал:

/мянган төгрөгөөр/

Харилцагч байгууллага	Үлдэгдэл	Авлагын насжилт	
		0-3 сар	12-36 сар
Гс.Сүмбэр ОНТатвар	163.2		163.2
ГХБХБГ	34.8		34.8
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.3	0.3	
Нийт дүн	198.3	0.3	198.0

Хүснэгтээс харахад: Нийт авлагын 99.8% нь 12-36 сарын насжилтай авлага байна.

Аудитаар тус байгууллагын өр төлбөр, авлагын бүртгэлийг тулган баталгаажуулахад бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил дутагдал илэрсэнгүй.

Харин аймгийн Татварын хэлтсээс авах авлагад бүртгэгдсэн 163.2 мянган төгрөгийн авлагыг татварын төрөл хооронд суутган тооцох, ГХБХБГ-аас авах авлагыг газрын төлбөрт тооцон хааж цаашид авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Хөрөнгийг хууль журмын дагуу бэлтгэж, үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх

Бүлэг 3

Хөрөнгийн эмх цэгц сайн боловч хөрөнгийг дансны ангиллын дагуу бүртгээгүй, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

3.1. 2016-2017 онд хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тус газарт 2016-2017 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлах бараа, ажил үйлчилгээний төсөв батлагдаагүй бөгөөд ХХААХҮЯ, УМЭАЦТЛ-иас нийт 50 төрлийн 48,929.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 6 төрлийн 669,213.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

3.2. Үндсэн хөрөнгө, тусгай зориулалтын материалыг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгээгүй байна.

Тус газар нь 2016 онд 607,272.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 194,169.3 мянган төгрөгийн бараа материал, 2017 онд 644,582.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 118,255.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тус тус тайлагнасан байна.

2016 онд үндсэн хөрөнгө нийт 1,550.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь УМЭАЦТЛ-иас хүлээлгэн өгсөн хөрөнгө байна.

2017 онд үндсэн хөрөнгө нийт 37,310.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс 860.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авч, 47,379.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ХХААХҮЯ-наас үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 7,461.1 мянган төгрөгийн хөрөнгийг хувьчилж, 3,468.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн жагсаалтыг харуулбал:

Д.д	Хөрөнгийн нэр	Тоо	Дүн	/мянган.төгрөг/ Олгосон газар
2016 он				
1	Иж бүрэн компьютер	1	1,150.0	УМЭАЦТЛ
2	Өнгөт хэвлэгч 3 үйлдэлтэй	1	400.0	
Дүн			1,550.0	
2017 он				
1	Dell inspiron зөөврийн компьютер	1	1,201.3	ХХААХҮЯ
2	Dell optiplex дэлгэцтэй компьютер	5	6,041.8	
3	Номын шкаф	10	3,500.0	
4	Оффисын сандал	10	1,000.0	

5	Оффисын тумбочка, шилэн хаалттай ширээ	10	3,200.0
6	Принтер	2	529.8
7	Принтер /print, copy, scan/	2	937.2
8	Тог баригч	5	626.5
9	УАЗ-220695-460 фургон автомашин	1	29,642.9
10	Хувцасны шкаф	2	700.0
Дүн			47,379.3

Бараа материал 2016 онд 377,609.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 308,960.4 мянган төгрөгөөр буурсан бөгөөд 5 төрлийн 4,424.5 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 4 төрлийн 373,185.0 мянган төгрөгийн материалыг ХХАААҮЯ-наас үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

2017 онд 301,787.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 377,700.8 мянган төгрөгөөр буурсан бөгөөд 5 төрлийн 5,759.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 7 төрлийн 296,217.3 мянган төгрөгийн материалыг ХХАААҮЯ болон “Инвест ко-оп” төслөөс үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын жагсаалтыг харуулвал:

/мянган.төгрөг/

Д/д	Нэр	2016 он	2017 он	Олгосон газар
1	Малын төл	965.0	1,156.0	ХХАААҮЯ
2	Эм	371,244.9	283,555.6	
3	Ногооны үр	937.5	710.2	
4	Бичиг хэрэг	38.0	189.2	
5	Мотоцикл		8,717.1	
6	Вирусын програм		189.2	
7	Майхан		1,700.0	
Нийт		373,185.0	296,217.3	“Инвест ко-оп” төсөл

2016 онд аймгийн ХХААГ-ын даргын 2016 оны А/23 дугаар тушаалаар бараа материалаас 17 төрлийн 2,612.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

2017 онд Монгол Улсын засгийн газрын 2012 оны 224 дүгээр тогтоол, Говьсүмбэр аймгийн Орон сууц хувьчлах хорооны 01 тоот тогтоолыг үндэслэн аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2017 оны 332 дугаартай албан бичгээр 4 өрөө орон сууц 7,091.0 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 346 тоот тогтоолоор 5 төрлийн тоног төхөөрөмж 3,838.2 мянга, нийт 10,929.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Анхан шатны баримтын бүрдлийг хангасан ба бараа материал, үндсэн хөрөнгийн тайланг сар бүр гаргаж архивласан байна.

Хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. ХХААГ-аас сумдын мал эмнэлгийн нэгжүүдэд вакцин, эм тариаг бараа материалын зарлагын баримтаар олгосон боловч сумдын мал эмнэлгийн тасгууд нь бараа материалын тайланг гаргаагүй байна.
2. Эм боох материалд 10 нэр, төрлийн 37,007.1 мянга, аж ахуйн материалд 16 нэр, төрлийн 8,893.4, бусад материалд 5 нэр, төрлийн 8,953.3 мянга, нийт 54,853.8

мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай тоног төхөөрөмжийг тус тус бүртгэсэн байна.

3. Бусад хангамжийн материалд 76 нэр, төрлийн 9,824.1 мянга, эм боох материалд 130 нэр, төрлийн 37,758.1 мянга, нийт 47,582.3 мянган төгрөгийн бараа материалыг тусгай зориулалтын материалд бүртгээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4,6 дугаар зүйлийн 6.1, 9 дүгээр зүйлийн 9.9.1, 13 дугаар зүйлийн 13.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, НБББББ-ийн 4 дүгээр бүлэгт тусгагдсан заалтуудыг тус тус зөрчсөн байна

Иймд эм боох материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанартай 37,007.1 мянга, ААМ-ын 8,893.4 мянга, бусад материалын 8,953.3 мянга, нийт 54,853.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалаас үндсэн хөрөнгийн дансанд, бусад хангамжийн материалын 9,824.1 мянга, эм боох материалын 37,758.1 мянга, нийт 47,582.3 мянган төгрөгийн бараа материалыг тусгай зориулалтын материалд тус тус шилжүүлэн бүртгүүлэх, байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сумдын мал эмнэлгийн үржлийн тасгуудаар анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын тайланг гаргуулах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.3. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

2017 оны жилийн эцсийн тайлангаар бараа материалын 7 дансанд 118,255.6 мянга, үндсэн хөрөнгийн 5 дансанд 644,582.6 мянган төгрөгийн нийт 762,838.2 мянган төгрөгийн бараа материал болон үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар 2016, 2017 оны жилийн эцсийн тооллогын комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон тооллогыг зохион байгуулж, Өмч хамгаалах байнгын зөвлөл нь тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэн бараа материалыг актлах, шилжүүлэх саналыг гаргаж, үндсэн хөрөнгийн орлогод авах, актлах, шилжүүлэх саналыг Орон нутгийн Өмчийн газарт хүргүүлж хэвшсэн байна.

Тус газарт нийт 644,582.6 мянган төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 505,424.4 мянга буюу 78.4% нь үйл ажиллагаанд ашиглагдаж, 139,158.2 мянган төгрөгийн хөрөнгө буюу 21.6% нь ашиглагдаагүй хөрөнгө байна.

Аудитын явцад өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг шалгахад дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. 2017 онд ХХААХҮЯ-наас үнэ төлбөргүй хүлээн авсан 5 төрлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг 2016 онд ХХАА-ын сайдын тушаалаар баталсан салбарын хэмжээнд дагаж мөрдөх НБББББ-т тусгасан хугацаанаас зөрүүтэй бүртгэсэн байна.

Ашиглалтын хугацааг зөрүүтэй тооцсон үндсэн хөрөнгийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Нэр төрөл	Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа		Зөрүү
		Санхүүгийн тайланд тусгасан	НБББББ-тусгасан	

1	Dell inspiron зөөврийн компьютер	4	3	1
2	Dell optiplex суурин компьютер	4	3	1
3	Принтер /print, copy, scan/	4	5	-1
4	Принтер	4	5	-1
5	Тог баригч	4	8	-4

Хүснэгтээс харахад: НБББББ-т тусгаснаас Зөөврийн болон суурин компьютерийн ашиглалтын хугацааг 1 жилээр илүү, принтерийн ашиглалтын хугацааг 1 жилээр дутуу, тог баригчийн ашиглалтын хугацааг 4 жилээр дутуу тооцсон байна.

- 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт үндсэн хөрөнгийн 23.3% буюу 42 нэр төрлийн 150,087.4 мянган төгрөгийн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байна. /Хөрөнгийн жагсаалтыг хавсралт №1-ээс үзнэ үү/
- Үндсэн хөрөнгө, тусгай зориулалтын болон эм боох материалд хийсэн түүвэр тооллогоор байгууллагын дансанд бүртгэлтэй 2,293.2 мянган төгрөгийн чулуун зоорь эвдэрч, байгууллагын үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон, иргэнд түрээсийн гэрээгээр өгсөн 1,045.0 мянган төгрөгийн жингийн толгой нь зөрүүтэй ирсэн, 11,715.9 мянган төгрөгийн хүйтэн хэлхээний камерийг зориулалтын байргүйн улмаас ашиглаагүй, “Чойр хайрхан” ХХК-нд түрээсийн гэрээгээр ашиглуулж буй 10,989.0 мянган төгрөгийн 2ш ноос пресслэгчээс 1 ш 5,494.5 мянган төгрөгийн ноос пресслэгчийг зориулалтыг өөрчлөн блок үйлдвэрлэсэн зэргээр нийт 20,548.6 мянган төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглаагүй байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, НБББББ-ийн 4.4 дэх заалтын заалтуудыг тус тус зөрчиж байна.

Иймд НБББББ-т заасан хугацаагаар үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг бүртгэж, тооцох, хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, эсхүл цаашид ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд хөрөнгийн ашиглах хугацаа, үнэлгээг тогтоох талаар холбогдох арга хэмжээ авч авах, хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөх, 20,548.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дотоод хяналт үр дүнтэй эсэх

Бүлэг 4

Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

4.1. Байгууллагын удирдлага дотоод хяналтын үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Тус газрын даргын 2016 оны А/07 тоот тушаалаар байгууллагын дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн, дотоод хяналт шалгалт, дотоод аудитын журмыг баталсан байна.

Дотоод хяналтын багийн ахлагчаар ХШҮДА хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргал, МААХ-ийн дарга Д.Дэлгэрмөнх, ХГТХ-ийн дарга Т.Эрдэнэбаяр нарыг томилсон байна.

Дотоод хяналтын баг нь хяналт шалгалтын төлөвлөгөө болон удирдамжийг газрын даргаар батлуулж, дүнг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнг тооцож ажилласан байна.

Дотоод хяналтын баг нь 2016 онд 6, 2017 онд 7 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2016 оны ажлын гүйцэтгэл 83.3%, 2017 оны ажлын гүйцэтгэл 100.0%-тай байна

Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:

Графикаас харахад: 2017 онд өмнөх оноос 14.2%-иар шалгалтын тоог нэмэгдүүлж төлөвлөсөн ба хяналт шалгалтыг бүрэн хийж гүйцэтгэсэн байна. 2016 онд хийгдээгүй 1 хяналт шалгалт нь ЦСҮТ-ийн үйл ажиллагаанд хийгдэх хяналт шалгалтын ажил байсан ба тус байгууллагаас шаардлагатай баримт, материалыг гаргаж өгөөгүйтэй холбоотой байна


2016 онд “Цөм сүрэг үржлийн төвийн үйл ажиллагаа”-нд дотоод аудит хийх төлөвлөгөөтэй байсан боловч тухайн байгууллага баримт материалаа ирүүлээгүй тул н шалгалт хийгдээгүй бөгөөд газрын даргын тушаалаар “Мал эмнэлгийн ариун цэвэр халдваргүйжүүлэлт”-ийн ажлын гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байна.

2017 онд гүйцэтгэлээр өмнөх оноос 25%-иар илүү хяналт шалгалт хийгдсэн ба энэ нь төлөвлөгөөнд тусгагдаагүй хяналт шалгалт хийсэнтэй холбоотой байна. Тухайлбал: Тус газрын ахлах нягтлан бодогч А.Отгонтуяагийн өргөдөл, “Мал эмнэлгийн малаас хүнд халдварладаг адууны ям, үхрийн сүрьеэ, өвчнийг оношлох шинжилгээг зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх” гэсэн төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

4.2. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналтын явцад ариутгал, халдваргүйжүүлэлтийн акт, баримт бичгийн стандартыг хангах, бодисын хэрэглэгдэх тунг зааврын дагуу хэрэглэх, нэгжүүдийн гаргаж байгаа тайланд хяналт тавих зэрэг зөрчлийг арилгуулах зөвлөмжийг МЭҮТ, МЭН-ийн эмч нарт хүргүүлэн, зөвлөмжийн хэрэгжилтийг ХШ-ын багийн хурлаар хэлэлцэж хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Хяналт шалгалтын мөрөөр хийгдсэн ажил үр дүнг үнэлж бүрэн хэрэгжээгүй ажлууд болон хэрэглэгчийн үнэлгээний судалгааг үндэслэн дараа оны ажлын төлөвлөгөөг гаргадаг байна.



2016 онд ХХААГ-ын ХШҮ-ээр нийт 9 заалт бүхий 3 зөвлөмжийг 4 албан тушаалтанд, 6 заалт бүхий 1 дүгнэлтийг 2 албан тушаалтанд тус тус хүргүүлж үр дүнг тооцсон ба зөвлөмж болон дүгнэлтийн биелэлт 85%-тай, 2017 онд хийгдсэн ХШҮ-ээр нийт 9 заалт бүхий 4 зөвлөмжийг 5 албан тушаалтанд хүргүүлж үр дүнг тооцсон ба зөвлөмж биелэлт 97.7 %-тай байна.

4.3. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас тус газрын 2016 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн ба 2017 оны санхүүгийн тайланд “Саруул Баян Уул-аудит” ХХК аудит хийж, Зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд нийт 1,934.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,111.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 331.7 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 492.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, төлбөрийн актыг барагдуулж ажилласан байна.

2017 онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус газрын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс 2015-2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баримт, НДШ, татварын тайлан, даргын тушаал холбогдох бусад баримтуудад хяналт шалгалт хийсэн бөгөөд хяналт шалгалтуудаар зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайн байна.

2016 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна. Тухайлбал: 2016 оны 1, 3, 9 дүгээр сарын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг мэдээ, бүтэн жилийн батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлт зөвлөмж, 5-р сард батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тус тус хугацаа хоцроож оруулсан байна.

2017 онд өмнөх оны зөрчил дутагдлыг арилгаж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан ба дутуу оруулсан болон хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Аудитын явцад нийт 262,685.7 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 344.9 мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, 20,548.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, 241,792.2 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Салбарын бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байна.
- Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг тооцох, үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх талаар идэвхи санаачлагатай ажиллах шаардлагатай байна.
- Салбарын бодлого, чиглэлийг баримтлан орон тооны дээд хязгаарт нийцүүлэн бүтэц, орон тоог баталсан боловч ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцээгүй ажилтныг авч ажиллуулсан, ажлын байрны сул орон тоо нөхөгдөөгүй байна.
- Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчсөн байна.
- Төсвийн төлөвлөлтөд хэмнэлтийн горимыг баримтлаагүй, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, тооцоолол хангалтгүй байна.
- Орлогыг нэр төрлөөр нь төлөвлөөгүй, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслээгүй байна.
- Төсвийн зардлыг үндэслэлтэй батлаагүйгээс зардал хооронд тодотгол хийж, бүлгээр хянагдах зардлын зүйл ангийг зөрчиж, цалингийн зардлаас тэтгэмж олгосон байна.
- Хөрөнгийн эмх цэгц сайн боловч 2016-2017 онд хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалыг дансны ангиллын дагуу бүртгээгүй, бүртгэлтэй хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.
- Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авчхэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ХХААГ-ЫН ДАРГА Ч.ОТГОНСҮРЭНД:

1. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнг тооцож ажиллах
2. Үндсэн чиг үүргийн хүрээнд хамаарал бүхий төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажлын уялдаа холбоогоо сайжруулах
3. Бүтэц, орон тооны дээд хязгаарыг баримтлан үйлчлэгч, манаачийн орон тоог батлуулах
4. Ажлын байрны сул орон тоог нөхөх арга хэмжээ авч, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтан авч ажиллуулах
5. Төсвийн төлөвлөлтийг холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа, тооцоолод үндэслэн боловсруулж батлуулах
6. Үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр, төрлөөр нь бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл зэргийг харгалзан үнэн зөв тооцож, төлөвлөх, орлого олох боломжийг судалж, орлогын төлөвлөгөөг жил бүр нэмэгдүүлж батлуулах
7. Үндсэн хөрөнгө, бараа материалыг дансны ангиллын дагуу үнэн зөв бүртгэх, байгууллагын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, үйл ажиллагааны эргэлтэд оруулах
8. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг НБББББ-т заасан хугацаагаар тооцож, бүртгэх, хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгүүдийг данснаас хасах, эсхүл цаашид ашиглах боломжтой гэж үзсэн тохиолдолд хөрөнгийн ашиглах хугацаа, үнэлгээг тогтоох талаар холбогдох арга хэмжээ авах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж ажиллах

СУМДЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ҮРЖЛИЙН ТАСАГТ:

1. Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын тайланг гаргаж байх
2. Сумын хэмжээнд ХАА-ын салбарын бодлого, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан гаргаж хэвших

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Говьсүмбэр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн санал:

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
42010 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр,
Утас/Факс: (976) 7054 3261, Э-мэйл: hhoaggaa@yahoo.com

2018.07.17 № 21/250
талай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд
өгөх санал байхгүй болно.

ДАРГА  Ч.ОТГОНСҮРЭН

УГА0025 901883
4215102337

D:Ajil/toot/A5toot.docx

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Говьсүмбэр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас тайлангийн төсөлд өгөх саналгүй тул тайланд өөрчлөлт ороогүй болно.